

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЦЭРГИЙН АЛБАНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭС

Я.Ариунболд

ДХИС-ийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн тэнхимийн профессор, хурандаа

Товч агуулга: Аюул, эрсдэл нь байнга оршин байдаг ерөнхий ойлголт. Аюулгүй байдал гэдэг бол хүний сэтгэл санааны амар тайван байгаа төлөв, түүнийг хангасан хүрээлэн буй орчин, төлөв байдал, аюулгүй байдлыг хангах гэдэг нь энэхүү амар тайван төлөв байдал, орчныг хангасан нөхцөл бүрдүүлэхийг хэлнэ.

Abstract: The general concept that danger and risk are always present. Security means a peaceful state of human mind and the environment that provides it, and security means creating conditions that provide this peaceful state and environment.

Түлхүүр үгс: Аюул, аюулгүй байдал, хор уришг, хор хөнөөл, аюулгүй байдлын түвшин, үндэсний аюулгүй байдал, байгууллагын аюулгүй байдал, Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны аюулгүй байдал

Keywords: Danger, security, harm, harm, level of security, national security, organizational security, Security of the military service of the Border Guard

Оршил

Аливаа мэдээллийг бүхэлд нь авч үзэхгүйгээр дур зоргоор, зах зухаас нь таслан авбал дүгнэлт хийх гэж оролдвол тэр нь хэнд ч хэрэггүй бөгөөд үнэлэлт, дүгнэлт хийхэд хортой үр дагавартай байдаг¹ гэж судлаачийн бичсэнтэй уялдуулан Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны аюулгүй байдал (цаашид ХХБЦААБ гэх)-ын онол, арга зүйг судлахад аюулгүй байдлын онол, аюулгүй байдлын тогтолцоо, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хилийн аюулгүй байдлын талаар судлах нь зүйтэй юм.

Нэг. Аюулгүй байдлын онолын үндэс, ойлголтын тухай.

Аюулгүй байдал нь аюул, занал, сорил, эрсдэл гэсэн үндсэн бүрэлдэхүүнтэй.

Аюул гэдэг нь өргөн хүрээтэй ойлголт юм. Аюул гэдэг нь сөнөөх, сүйтгэх шинж чанар бүхий объект, хүчин зүйлсийн зүгээс хүн, байгаль, ямар нэгэн зүйлд хор хохирол учруулах магадлалын тухай ойлголт юм. Аюулын нэлээд тодорхой объектод чиглэсэн, түүнийг онилсон хэлбэрийг занал гэж үздэг.² Аюул нь логикийн хувьд анхдагч ойлголт юм. Энэ нь хийсвэр, тодорхой, бодитой байж болно. Хийсвэр аюул гэдэг нь аюулгүй байдал тухайн агшинд бодитой болох нөхцөл бүрдээгүй байдлаар хязгаарлагдаж байдаг. Ийм нөхцөл бүрэлдсэн болон тухайн объектод чиглэсэн аюулын дохио

¹ Арвай Ш. Аюулгүй байдлыг чандлан хангаваас бидний эх орон мөнх оршино. Уб., 2020. 20 дахь тал.

² Прохожев А.А. Общая теория национальной безопасности. /https://www.studmed.ru/view/prohozhev-a-obschaya-teoriya-nacionalnoy-bezopasnosti_197fc1b77f7.html/

өгсөн үед тодорхой аюул болно. Чиглэл, зорилготой үйл ажиллагааны үр дүнд, эсвэл хүмүүсийн бодол, эргэцүүлэлд аяндаа мэдрэгдэж, анхаарал татсан, эсвэл үнэхээр бий болоод байгаа аюул нь занал болж даамжирна. Ингэхээр аливаа аюул нь өөртөө ямар нэгэн байдлаар заналыг дагуулж байдаг ажээ¹. Бодит амьдрал дээр янз бүрийн аюулууд урьд байсан, одоо ч байгаа, цаашид байсаар байх нь тодорхой юм. Ийм учраас аюулгүй байдлын өнөөгийн агуулгыг "аюулаас бодитойгоор хамгаалагдсан байдал, түүнийг найдвартай сөрөн зогсох чадвар"² гэж тодорхойлсон байна. Хүн төрөлхтөний хөгжлийн бүхий л үед хүмүүс болоод нийгэмд аюул, занал учруулж ирсэн олон төрлийн байнгын эх үүсвэр бий.

Цэргийн болон хилийн нэр томъёоны тайлбар тольд: Аюул-байгаль орчны доройтол, нийгэм, эдийн засгийн уналт, улс төрийн хямрал зэргээс хамаарч эд хөрөнгө сүйрэх, хүний амь нас эрсдэх, бэртэл гэмтэл авах шалтгаан болох зэргээр хөнөөл учруулж болзошгүй аливаа үзэгдэл, тохиолдол, хүний үйл ажиллагаа. Аюул нь байгалийн, (геологийн, ус цаг уурын, биологийн) болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй (хүрээлэн буй орчны доройтол, технологийн, нийгэм, улс төр) г.м өөр өөр гарал үүсэлтэй байдаг. Аюул нь ирээдүйд заналд шилжих, улмаар сүйтгэл, хохирол учруулах далд нөхцөлийг агуулж

байдаг. Аюул нь гарал үүсэл, үзүүлэх үр нөлөөнөөсөө хамаараад дан, дараалсан, хосолсон хэлбэртэй байдаг. Аюул бүр нь түүний байршил, эрчимжил, давтамж, магадлалаараа өөрийн гэсэн онцлог шинжтэй байдаг³ гэсэн бол;

Аюул гэдэг нь англи хэлнээ "threat", орос хэлэнд "угроза", харин монгол хэлнээ "аюул" гэсэн утгаар хэрэглэж байна. Монгол хэлний тайлбар тольд "аюул" – гамшиг зовлон учруулж болох хор хөнөөлтэй юм, "занал" – заных үйлийн нэр⁴, харин Вебстерийн (Merriam Webster) тайлбар тольд "threat" гэдэг нь "муу зүйл, гэмтэл, эсвэл хохирол учруулах зорилгын илрэл"⁵ гэж тодорхойлсон байна.

Аюул нь олон янзын хэлбэрээр оршин тогтнож болно. Аюулын тухай орчин үеийн үзэл баримтлалд тулгуурлан уламжлалт аюул, уламжлалт бус аюул гэж ангилж байна. Уламжлалт бус аюул гэж орчин үед гарч ирсэн шинэ аюулууд тухайлбал терроризм (хорлон сүйтгэх ажиллагаа, хэт даврах ажиллагаа), хар тамхи, хүний наймаа, гоц халдварт өвчин, далайн дээрэм, хууль бус цагаачлал, орчны аюулгүй байдал, санхүү, эдийн засаг, мэдээллийн аюулгүй байдалд нүүрлэсэн аюулыг хэлдэг болжээ⁶.

Эмзэг байдал нь англи хэлнээ "vulnerable", орос хэлэнд "уязвимый" гэсэн утгаар хэрэглэгддэг бөгөөд аюулгүй байдлын ойлголтод аюул

¹ Эрдэнэчимэг Б. Аюулгүй байдлын чиг хандлага өөрчлөлт, батлан хамгаалах бодлогод нөлөөлөх нь. Уб., 2016. 10 дахь тал.

² Бельков О.А. Понятийно-категориальный аппарат концепции национальной безопасности. М., 1994. №3. стр. 91.

³ Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. Уб., 2014. 56 дахь тал.

⁴ Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 1966. 60 дахь тал.

⁵ www.merriam-webster.com

⁶ Төмөрчулуун Г. Уламжлалт бус аюулын зарим асуудал. Монгол Улсын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. Уб., 2014. 161 дэх тал.

гэсэн утгатай ойролцоо хэрэглэгддэг ч түүнээс ялгаатай юм. Ханс Г.Б. “эмзэг байдал гэдэг нь гадны нөлөөнд өртөх нөхцөл байдал, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд хангалтгүй чадавх”¹ гэж тодорхойлжээ.

Заримдаа аюул нь эрсдэлийн хэлбэрээр илэрч болно. Эрсдэл нь аюул, эмзэг байдал хоёрын харилцан үйлчлэл хэдий ч зарим тохиолдолд гаднын аюулын оролцоогүйгээр эмзэг байдал нь аюул болж хувирах эрсдэл байдаг. Энэ тохиолдолд эрсдэлийн агуулга нь гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд хор хохирол учруулах бус харин шийдвэрлэхээр зорьсон зорилгоосоо хазайх боломжид агуулагдаж байх магадлалтай байдаг ба нүүрлэж болох хор хохирлыг цаг хугацаа, орон зайн хувьд урьдаас тооцоогүй сөрөг үйл явдал байж болно. Үйл явдал бүхэн ямар нэг хэмжээний эрсдэлийг дагуулж байдаг, түүнийг ямар нэг байдлаар багасгаж, хорогдуулж болох ч эрсдэлийн төвшнийг “тэглэх” гэсэн ойлголт байх боломжгүй юм. Мөн удирдахуйн онолд эрсдэлийн талаар “шийдвэрийн үр дүнг баталгаатай хэлж чадахгүй нөхцөл байдлыг эрсдэл гэнэ”² гэжээ.

Сорил (challenge, вызов) хэмээх ухагдахуун нь олон улсад аюулгүй байдалтай холбоотой хэрэглэгдэж байгаа боловч энэ талаарх тодорхойлолт тийм олон биш ба ихэнх тохиолдолд “аюул” гэсэн

утгатай ижил утгаар хэрэглэж байна. Монгол хэлний их тайлбар тольд “сорилт”³ гэдэг сорих үйлийн нэр бөгөөд хүнд бэрх сорилт гэсэн утгаар тайлбарлажээ. Сорилт нь аюулыг бодвол бодит заналхийлсэн шинжгүй бөгөөд аюул нүүрлэх эхний үе шат гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл сорилт нь хэдий яг аюул нүүрлээгүй ч түүнийг эс анхаарваас цаашдаа аюулгүй байх бололцоогүй гэсэн үг юм⁴.

Тэгвэл “аюулгүй байдал” гэж юу вэ? Эрдэмтэн судлаачид “аюулгүй байдал” гэдэг ерөнхий ойлголтыг янз бүрээр тайлбарласан байдаг. Энэ ойлголт тодорхой тохиолдолд субъектийн аюулгүй байдлын өвөрмөц онцлогийг илэрхийлэхийн зэрэгцээ, олон салбарт хэрэглэж болох нийтлэг утга санаа агуулагдаж байдаг. Аюулгүй байдлын талаарх энэхүү ойлголтыг “Британика” нэвтэрхий тольд “аюулгүй байдал-амар тайван, бат бэх, итгэлтэй байх нөхцөл байдал, аюул болон эрсдэлээс чөлөөтэй байх”, Оксфордын англи хэлний тольд “аюулгүй байдал-амар тайван, бат бэх итгэлтэй нөхцөл”, гэсэн бол Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд “аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй”⁵, В.Далийн тайлбар тольд: “аюулгүй байдал гэдэг бол аюулгүй, бүрэн бүтэн байх, найдвартай, итгэлтэй байх”⁶ гэж тайлбарлажээ. Аюулгүй байдлын өнөөгийн агуулгыг “аюулаас бодитойгоор хамгаалагдсан

¹ Huns Gunter Brauch. Concepts of Security Threats, Challenges, Vulnerabilities and Risks. USA., p68.

² Готов Д. Менежментийн үндэс. Уб., 2010. 56 дахь тал.

³ www.mongoltoli.mn

⁴ Булган Д. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг,

эрх зүйн зохицуулалт. Хууль зүйн докторын зэрэг горилсон диссертаци. Уб., 2017. 15 дахь тал.

⁵ Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 1966. 60 дахь тал.

⁶ Даль В.И. Толковый словарь русского языка. М., 2001. стр 44.

байдал, түүнийг найдвартай сөрөн зогсох чадвар"¹, Оросын холбооны улсын албан ёсны үзэл баримтлалд: “аюулгүй байдал гэдэг нь улс, нийгэм, бие хүний амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдлыг хэлнэ.” Аюулгүй байдлыг:

- улсын аюулгүй байдал;
- нийгмийн аюулгүй байдал;
- бие хүний аюулгүй байдал

гэж ангилна ² гэж тус тус тодорхойлсон байна.

Аюулгүй байдал гэж-олон улсын, улс үндэстний, хамт олны, түүгээр ч барахгүй хувь хүний хэмжээнд түгээмэл хэрэглэгддэг ажил амьдралын амгалан тайван орчин нөхцөлийн тухай ерөнхий ойлголт. Улс үндэсний аюулгүй байдлыг түүний оршин тогтнохын, нийгэм-улс төрийн гэж авч үзэх нь бий. Үндэсний аюулгүй байдал нь хүний, хүнсний, экологийн, удмын сангийн г.м тодотголтой хэрэглэгддэг. Үндэсний аюулгүй байдал нь улс орны үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлж, тал бүрийн баталгаа буй болгоход чиглэсэн төрийн бодлого, төр түүний байгууллага, албан тушаалтнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээр хангагдана. Үндэсний аюулгүй байдлыг нийгэм, улс төрийн, эдийн засгийн, дипломатын, цэргийн, хууль зүйн аргаар дангаар буюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангадаг³.

Олон улсад аюулгүй байдал нь “safety”, “security” гэсэн нэр томъёогоор илэрхийлэгддэг. “Safety” гэдэг нь аливаа зүйлд хор хохирол учрахаас болон бусад хүсээгүй үр дагавраас хамгаалж аюулгүй байх нөхцөл байдал юм⁴. Мөн аюулгүй байдлын тухай ойлголтод эрсдэл, түүнийг хүлээн зөвшөөрөгдөх төвшин, түүнд хүргэхийн тулд аюулыг хянах асуудлыг хамруулан ойлгодог. Аюулгүй байдал буюу “Safety”-тай холбоотойгоор “Security” буюу “хамгаалалт” (аюулгүй байдлыг хангах, хамгаалах) гэсэн нэр томъёог хамтад нь ихэвчлэн хоршиж, сольж, адилтгаж, нэг өгүүлбэрээр, бие биетэй нь зэрэгцүүлэн хэрэглэх нь англи хэлэнд олонтаа⁵.

Вебстер (Merriam-webster)-ийн олон улсын тайлбар тольд safety буюу аюулгүй байдал гэсэн нэр томъёог дараах байдлаар тайлбарлажээ.

1. хор уршиг, эрсдэлээс ангид байх нөхцөл байдал юм;
2. аюулгүй буюу хор хөнөөлгүй байх нөхцөл;
3. аюулгүй газар: хохирол эсвэл аюулаас ангид газар⁶ гэж тайлбарлажээ.

Уг тольд security гэдэг нь “аюулгүй байдал, хамгаалалт⁷” гэж орчуулагдаж, “хор уршиг, хөнөөлөөс хамгаалагдсан байдал”, “хууль бус үйлдлийг шалгаж, аюулгүй байдлыг

¹ Бельков О.А. Понятийно-категориальный аппарат концепции национальной безопасности. М., 1994. №3. стр 91.

² Концепция национальной безопасности Российской Федерации. Утверждена Указом Президента Российской Федерации от 12 мая 2009 г. №537.

³ Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн. “Цэргийн нэр томъёоны тайлбар толь” УБ., 2014. 57 дахь тал.

⁴ <https://en.wikipedia.org/wiki/Safety>

⁵ Булган Д. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг, эрх зүйн зохицуулалт. Хууль зүйн докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2017. 16 дахь тал.

⁶ <http://www.merriam-webster.com/dictionary/safety>.

⁷ www.bolor-toli.com

хангах ажиллагаа ¹ ” гэж тайлбарлажээ. Эдгээр нэр томъёо (safety and security) нь хоорондоо харилцан хамааралтай ухагдахуун юм ². Тухайлбал, аюулгүй байдлын хамгаалалт сулрахад эрсдэл нэмэгддэг бол аюулгүй байдлын үзүүлэлтүүд түүнийг дагаж буурдаг байна. Нөгөө талаас аюулгүй байдлын хамгаалалт сайжрахад эрсдэл буурдаг байна. Тиймээс аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангах хоёрын хооронд шууд пропорционал хамааралтай.

Энгийн утгаар аюулгүй байдал гэдэг ухагдахууныг авч үзвэл хэвийн оршин тогтнох, хөгжих зорилго бүхий цогц асуудал ³ байдаг. Аюулгүй байдлыг өргөн хүрээтэй, цогцоор авч үзэж байгаа нь аюулын мөн чанар өөрчлөгдөж, анхаарлын төвд төр улс биш, хүнийг тавих шаардлагатай болсон талаар судлаачид холбон үзжээ ⁴.

Ц.Цэрэндорж нар “Аливаа байгууллага нь улс төр, эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухаан технологийн хөгжил, хүн ам зүй, байгаль экологи зэрэг нийгмийн амьдралын бүхий л хүрээнд шууд болон шууд бус нөлөөлөл дор оршин тогтнож байдаг. Эдгээр нөлөөллийн эерэг болон сөрөг талуудыг хэрхэн хүлээн авч шийдвэрлэснээр тухайн байгууллага үүргээ амжилттай биелүүлж нэр хүнд нь өснө.

Байгууллагын аюулгүй байдал, түүнийг хангах гэдэг нь үндсэн үүргээ биелүүлэхэд шууд, шууд

бусаар нөлөөлж буй сөрөг, таагүй хүчин зүйлүүд тэдгээрийг даван туулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын цогц үйл ажиллагаа юм.

Байгууллагад нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг нөлөөллөөр нь гадаад дотоод, үүсэх үр дагавар нь шууд ба шууд бус нөлөөлөх хүчин зүйлс гэж ангилж болно. Өөрөөр хэлбэл улс орны төрийн байгууламж, эдийн засгийн байдал, соёл боловсролын төвшин, байгаль экологи, гэмт хэргийн өсөлт, бууралт болон дээд шатны байгууллагын удирдлага, зохион байгуулалт, харилцагч байгууллагын байдал зэрэг нь гадаад хүчин зүйлс болно.

Тухайн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, салбар нэгжүүдийн харилцан ажиллагаа, уялдаа холбоо, удирдлагын арга барил, хамт олны боловсрол, эрүүл мэнд, амьдралын төвшин, мэргэжлийн ур чадвар, тогтоосон дэг журам, мэдээлэл, материаллаг үнэт зүйлсийг хэрхэн хуваарилан ашиглаж байгаа, технологийн горимыг нарийн чанд мөрдөж буй эсэх, сахилга бат зэрэг нь дотоод хүчин зүйлс болно” ⁵ гэжээ.

Аюулгүй байдлыг өнөө үед ихэнх улс дараах байдлаар ангилж байна. Үүнд:

- олон улсын (даяаршлын буюу бүх нийтийн, дэлхийн);
- бүс нутгийн аюулгүй байдал;

¹ www.merriam-webster.com(dictionary)security

² Byres E.J, Cusimano J. “Safety and Security: Two Sides of the Same Coin”, Control Global, April 2010. (www.controlglobal.com)

³ Батбаяр Б. Аюулгүй байдлын шинэ орчин, Монголын үүрэг оролцоо. Стратеги судалгаа

20 жилд. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. Уб., 2011. 7 дахь тал.

⁴ Мөнх-Очир Д. Аюулгүй байдлын судалгааны онол, практикийн асуудал. Стратеги судлал. №28. Уб., 2004. 99 дэх тал.

⁵ Цэрэндорж Ц., Цэрэндамба С. Бидний менежмент. Уб., 2010. 130 дахь тал.

- үндэсний (төр, улсын) аюулгүй байдал болно.¹

Аюулгүй байдлыг сахих үйл ажиллагаа нь нийгэмд зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа, хил хамгаалалтын болон онцгой байдлын албаны зэрэг хүчний байгууллагын бүтцийг буй болгон, улмаар бүхэлдээ дэлхий ертөнцийн нийт хүн амын аюулгүй байдлыг хангах үүрэгтэй НҮБ-ыг байгуулахад хүргэсэн байна.

Аюулгүй байдлын онолын үндэс гэж шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоонд өөрийн байр суурийг эзэлдэг аюулгүй байдлын ерөнхий онол байдаг. Түүний зэрэгцээгээр аюулгүй байдлын судалгааг тодорхой чиглэлүүдээр явуулдаг бөгөөд тэдгээр нь өөр өөрийн онолтой байдаг. Аюулгүй байдлын ерөнхий онолыг бүрдүүлэгч шинжлэх ухаан нь гүн ухаан, нийгэм судлал, улс төр судлал, эдийн засгийн шинжлэх ухаан, мөргөлдөөн судлал, сэтгэл зүй, хууль зүйн шинжлэх ухаан, системийн судлал, улсын хил судлал зэрэг юм. Аюулгүй байдлын ерөнхий онол нь өөрийн тусгай статусаар тухайн салбарын цогц асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгааны онцгой чиглэл гэж үзэж болно. Үүгээрээ ерөнхий онолын систем гэж нэрлэгддэг тогтолцооны судлал (системология), мөргөлдөөнт байдлын онол (конфликтология), удирдлагын ерөнхий онол (кибернетик), өөрийн зохион байгуулалтын онол (синергетик)

зэрэгтэй адил байх болно. Шинээр буй болсон улсын хил судлал энд хамаарагдана.

Б.Бузан (Arnold Wolfers) аюулгүй байдлын талаар авч үзэхдээ “аюулгүй байдал нь аюулын судалгаанд үндэслэж, аюулд тохирсон шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдал”² гэж тодорхойлсон. Тэрээр аюулгүй байдлыг зөвхөн төрийн хүрээнд авч үзэх бус хүний аюулгүй байдлыг цогцоор нь авч үзэх таван гол салбарыг тодорхойлсон байна³ Үүнд: Цэргийн, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, байгаль орчны салбарт ангилж авч үзсэн.

Аюулгүй байдлыг хангах гэдэг нь чухам ямар зүйлийн аюулгүй байдлыг хангах талаар авч үзэж байгаагаас шалтгаалан тодорхой хэмжүүрээр тодорхойлогдсон арга хэмжээнүүдийн нэгдлийн тухай ойлголт юм⁴ гэжээ.

Цэргийн нэр томьёоны тайлбар тольд: “аюулгүй байдлыг хангах зам - болзошгүй аюулыг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, хамгаалахад чиглэсэн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх аргууд”⁵ гэж тайлбарлажээ. Аливаа аюулгүй байдлыг хангахын тулд аюулгүй байдлын үзэл баримтлал, шинжлэх ухааны үндэслэлтэй дүрэм, заавар боловсруулах нь чухал. Энэ нь тухайн аюулгүй байдлыг хангах талаар гаргах бусад эрх зүйн актуудын үндэс, үйл ажиллагааны

¹ Эрдэнэчимэг Б. Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого. УБ., 2016. 20-21 дэх тал.

² Arnold Wolfers. National Security as an Ambiguous Symbol. Political Science Quarterly 67(4): 481-502. Political Science Quarterly, Vol. 67, (Dec., 1952), 481-502.

³ Paul D. Williams. Security studies: An Introduction. P4. www.ebook777.com.

⁴ Очгэрэл Ц. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох нь. Хууль зүйн докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2016. 28 дахь тал.

⁵ Цэргийн нэр томьёоны тайлбар толь. УБ., 2014. 57 дахь тал.

удирдлага болдог. Аюулгүй байдлыг хангахын тулд аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Цэргийн алба хаагчийн аюулгүй нөхцөлд тэдний эрх зүй, нийгмийн хамгаалал, санхүү, материаллаг хэрэгцээгээр хангагдсан байдал, ёс суртахуун, сэтгэл зүйн тааламжтай орчин, эрүүл мэндийн хамгаалал, байр орон сууц, ажлын байр, хөдөлмөр, эрүүл ахуй, экологийн аюулгүй орчин болно.

Аюулгүйн байдлыг хангах ерөнхий аргачлал нь:

- тухайн аюулгүй байдлын төлөв шинжийн талаар мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх;

- аюул эрсдэлийг цаг тухайд нь илрүүлэх, зайлуулах;

- аюулгүй нөхцөлийг тодорхойлох, аюулгүй байдлыг хангах арга зам, чиглэл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, хэрэгжилтийг хянах, шалгах, дүгнэх;

- дүгнэлтүүдээс дахин шинээр авах арга хэмжээнүүдийг зөв тодорхойлж хэрэгжүүлснээр аюулгүй байдал хангагдана гэж үзэж болох юм.

Аюулгүй байдлын зарчмууд нь хүний төлөө байх, хууль эрх зүйн хүрээнд байх, аюул эрсдэлийн эсрэг арга хэмжээ нь цаг үеэ олсон буюу өрсөн байх, бусад аюулгүй байдлын арга хэмжээтэй харилцан уялдаатай байх, субъектүүдийн үүрэг, хариуцлагыг зааглан тогтоосон байх зэрэг үндсэн зарчимтай байж болох авч аюулгүй байдлын систем бүр өөр өөрсдийн онцлог, нөхцөлөөс

шалтгаалж зарчмаа тодорхойлох нь зүйтэй.

Хоёр. Аюулгүй байдлын тогтолцоо, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хилийн аюулгүй байдлын талаар.

Цэргийн нэр томъёоны тайлбар толь: “Аюулгүй байдлын тогтолцоо гэдэг нь нийгэм, төр, хувь хүний ашиг сонирхол, төр засгийн бүтцэд суурилсан эрх зүйн хэм хэмжээний цогц акт; улс төр, эдийн засаг, зохион байгуулалт, эрх зүй, үзэл суртлын харилцан уялдаатай цогц арга хэмжээний нэгдэл”¹ гэж тайлбарласан. Г.Лхагвамаа “манай улсад хувийн аюулгүй байдлын тогтолцоо нь өмч эзэмшигчид, бизнесийн үйл ажиллагааныхаа аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор корпорац, компанийн бүтцэд байгуулсан аюулгүй байдал, хамгаалалтын алба (proprietary service)² болон үйлчлүүлэгчдийн хувийн аюулгүй байдлыг гэрээний үндсэн дээр хамгаалах гэрээт харуул хамгаалалтын алба (contract service)³ гэсэн хоёр хэлбэрээс тогтож байна”⁴ гэжээ.

Эндээс “аюулгүй байдлын тогтолцоо гэж тодорхой зорилготой, эрх зүйн хэм хэмжээ, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагууд тэрчлэн аюулгүй байдлын найдвартай хамгаалалтыг хангах зориулалт бүхий дээрх байгууллагуудын техник, хэрэгсэл, арга, чиглэлийн нэгдэл юм” гэж үзэв.

¹ Цэргийн нэр томъёоны тайлбар толь. Уб., 2014. 57 дахь тал.

² Karen M. Hess. Introduction to Private Security. Wadsworth, Cengage learning. 2009. P 23-24

³ Мөн тэнд.

⁴ Лхагвамаа Г. Аюулгүй байдлын “хувийн салбар”-ын өнөөгийн байдал. Эрдэм шинжилгээний өгүүллэг. “Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд”. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб. 2016. 124 дэх тал.

Судлаачдын бүтээлийг харьцуулан судлахад аюулгүй байдлын тогтолцоо, аюулгүй байдлыг хангах тогтолцоо гэсэн нэр томъёо хэрэглэгдэж байна. Эдгээр нь хоорондоо ойролцоо мэт боловч агуулгын хувьд ялгаж үзэх нь зүйтэй бөгөөд аюулгүй байдлын тогтолцоо нь илүү өргөн хүрээтэй ойлголт юм.

Аюулгүй байдлын объектод аюул, занал хэрхэн нөлөөлж байгаагаас нь хамаараад аюулгүй байдлыг төрөлжүүлэн ангилж, бүрэлдэхүүн, хамрах хүрээг тодорхойлж, эрх зүйн хэм хэмжээ, аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагын зохион байгуулалтын бүтэц зэрэг нь аюулгүй байдлын тогтолцоог бий болгож, бүрдүүлж байна.

Харин аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, түүний чиглэлээс хамаарч төрөлжүүлсэн зохион байгуулалт, бүтэц, тэдгээрээс хэрэгжүүлэх хүч хэрэгсэл, чадавх, арга хэмжээний нийлбэрийг хэлнэ¹ гэсэнтэй санал нэгдэж байна.

Манай улсын хувьд аюулгүй байдлын тогтолцооны үндсэн суурь баримт бичиг нь “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” юм. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай

нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ”² гэж заасан.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны талаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дөрөвдүгээр зүйлд тодорхой тусгажээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудад: (долоодугаар зүйл)

а) байгаль орчныг хамгаалах алба;

б) гаалийн алба;

в) дипломат алба;

г) гамшгаас хамгаалах алба;

д) мэргэжлийн хяналтын алба;

е) зэвсэгт хүчин, бусад цэрэг;

ё) татварын алба;

ж) тусгай алба;

з) гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба;

и) иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн алба;

к) цагдаагийн алба тус тус орно. Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах үүрэгтэй³ гэжээ.

Мөн үзэл баримтлалд УАБ-ыг хангах үйл ажиллагааны зарчмыг:

- эх оронч үндэсний үзлийг дээдлэх;

- төр, иргэний хамтын ажиллагаа;

- аюулгүй байдлын бодлого цогц байх;

¹ Булган Д. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг, эрх зүйн зохицуулалт. Хууль зүйн докторын зэрэг горилсон диссертац. Уб., 2017. 24 дэх тал.

² УИХ-ын 48 дугаар тогтоол. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Уб., 2010. 1.1.1 дүгээр зүйл.

³ Монгол Улсын хууль. Үндэсний аюулгүй байдлын тухай. Уб., 2001. 6-7 дугаар зүйл.

- мэдлэгт суурилах;
- бодитой хандах;
- даяаршлын хүчин зүйлийг харгалзах гэж заасан бол Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга замыг:

- оршин тогтнохуйн аюулгүй байдал;

- эдийн засгийн аюулгүй байдал;

- дотоод аюулгүй байдал;

- хүний аюулгүй байдал;

- хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал;

- мэдээллийн аюулгүй байдал гэж хуваасан.

Ийнхүү дээрх үзэл баримтлал, хуульд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны зорилт, бүтэц, удирдлага, үүрэг, хяналт тавих тогтолцоо, хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд, зарчим, хангах арга замын чиглэлүүдийг тус тус хуульчилжээ.

Онолын хувьд “аюулгүй байдлын тогтолцоо (систем) - тодорхой зорилготой эрх зүйн хэм хэмжээ, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагууд тэрчлэн аюулгүй байдлын найдвартай хамгаалалтыг хангах зориулалт бүхий эдгээр байгууллагуудын техник, хэрэгсэл, арга, чиглэлийн нэгдэл юм”¹ гэж үздэг нь ба манай улсын дээрх аюулгүй байдлын тогтолцоо нь энэхүү онолын тодорхойлолттой нийцэж байна.

Сэдвийн хүрээнд ҮАБ-ын дээрх тогтолцооны бүрэлдэхүүн буюу дэд систем болох “Хүний аюулгүй байдал”-ын асуудлыг судлахад: Бүх аюулгүй байдал нь

хоорондоо нягт холбоо уялдаатай бөгөөд эцсийн эцэст үндэсний аюулгүй байдал, түүний цөм болсон хүний аюулгүй байдлыг хангахад чиглэгддэг болох нь судалгаанаас тогтоогдсон. Түүнчлэн хүн бол аюулгүй байдлын үндсэн объект бас субъект мөн. Онолын хувьд зөвхөн энэ хандлага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад цэргийн албаны аюулгүй байдлын асуудлыг авч үзэх үндсэн зарчимтай гэж үзэх нь зүйтэй.

Үндэсний аюулгүй байдал шиг хилийн аюулгүй байдлыг хангах чиглэлүүд нь улсын хилийн хамгаалалтад оролцож байгаа хүч, хэрэгслүүдийн үйл ажиллагааны нутаг дэвсгэр, орон зайн хүчин зүйл болон улс оронд учирч байгаа буюу учирч болзошгүй аюул заналын төрлүүдээр тодорхойлогддог. Үүнтэй уялдан улсын хилийн аюулгүй байдлыг бүрэлдүүлж буй чухал төрлүүд нь үндэсний аюулгүй байдлын улс төр, эдийн засаг, цэрэг, экологи, оюун санааны болон бусад төрлүүд болно.

Хилийн тухай хуулийн тавдугаар зүйлд “Монгол Улсын хилийн аюулгүй байдал”-ын талаар доорх байдлаар тусгасан. Үүнд:

- Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь (Цаашид “Хилийн аюулгүй байдал” гэх) Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн.

- Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ.

¹ Улаанхүү Ч. Аюулгүй байдал. УБ., 2009. 107 дахь тал.

- Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана.

- Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна ¹ хэмээн “Хилийн аюулгүй байдал” гэх ойлголт, асуудлын үндэс суурийг тавьж тодорхойлсон билээ.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах явдал нь төрийн үйл ажиллагааны чухал үндсэн чиглэл бөгөөд эцсийн дүндээ, хилийн аюулгүй байдал нь улсын хилийн хамгаалалтад оролцож буй субъектуудын системийн үйл ажиллагаагаар хангагдана. Энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх системийн хэсэг болох улсын хилийн хамгаалалт нь улс төр, зохион байгуулалт-эрх зүй, дипломат, эдийн засаг, батлан хамгаалах, тагнуул, оператив-эрэл тагнуул, гааль, байгаль орчин, ариун цэвэр-халдвар судлал, экологийн болон бусад арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх замаар өөрсдийн бүрэн

эрхийн хүрээнд Монгол Улсын төрийн эрх мэдлийн байгууллагууд, субъектуудын болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахад оршино гэснээр илэрхийлэгдэнэ.

Улсын хилийн хамгаалалт нь хувь хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхлыг хангах бөгөөд түүнийг Монгол Улсын хуулиар тогтоосон бүрэн эрхийнхээ дагуу гүйцэтгэх засаглалын бүх байгууллагууд хэрэгжүүлнэ. Улсын хил хамгаалах арга хэмжээ нь хилийн арга хэмжээ байна. Хилийн арга хэмжээ нь улс, нийгэм, хувь хүний амин чухал ашиг сонирхолд учирч болзошгүй холбогдох аюул заналын болон хилийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн хилийн бодлогын хүрээнд хэрэгжих, аюулгүй байдлын арга хэмжээнүүдийн системд ордог.

Дүгнэлт

Судалгаанаас “аюул, эрсдэл нь байнга оршин байдаг ерөнхий ойлголт. Аюулгүй байдал гэдэг бол хүний сэтгэл санааны амар тайван байгаа төлөв, түүнийг хангасан хүрээлэн буй орчин, төлөв байдал, аюулгүй байдлыг хангах гэдэг нь энэхүү амар тайван төлөв байдал, орчныг хангасан нөхцөл бүрдүүлэхийг хэлнэ” гэж дүгнэж байна.

Аливаа аюулгүй байдлын тэр тусмаа хилийн аюулгүй байдлын тогтолцоо нь өөрийн гэсэн зорилго, үүрэг, объект, субъект, аюул эрсдэл, нөхцөл, хангах арга хэрэгсэл, аргачлалтай ч онол арга зүйн асуудал нь нийтлэг зүй тогтолтой болно.


¹ Монгол Улсын хилийн тухай хуулийн 5 дугаар зүйл.

Түүнчлэн ХХБЦААБ-ын онолын үндэс нь аюулгүй байдлын тусгай онолд харьяалагдах дээрх аргачлалаар тодорхойлогдсон

аюулгүй байдлын бие даасан систем юм.

Дээрх судалгаанаас ХХБЦААБ-ын онол, практикийн хамаарлыг дараах бүдүүвчээр гаргав.

Хүснэгт 1. Цэргийн албаны аюулгүй байдлын тогтолцоо
ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЦЭРГИЙН АЛБАНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦООНЫ
ОНОЛ ПРАКТИКИЙН ХАМААРАЛ



Эх сурвалжийн жагсаалт:

- Ш.Арвай. Аюулгүй байдлыг чандлан хангаваас бидний эх орон мөнх оршино. УБ., 2020 он

- Прохожев А.А. Общая теория национальной безопасности.

- Б.Эрдэнэчимэг. Аюулгүй байдлын чиг хандлага өөрчлөлт, батлан хамгаалах бодлогод нөлөөлөх нь. УБ., 2016 он.

- Бельков О.А. Понятийно-категориальный аппарат концепции национальной безопасности. М., 1994 он

- Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2014 он.

- Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он.

- Г.Төмөрчулуун. Уламжлалт бус аюулын зарим асуудал. Монгол Улсын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ., 2014 он.

- Д.Готов. Менежментийн үндэс. УБ., 2010 он.

- Д.Булган. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг, эрх зүйн зохицуулалт. Хууль зүйн докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2017 он

- Ц.Цэрэндорж, С.Цэрэндамба. Бидний менежмент. УБ., 2010 он

- Б.Эрдэнэчимэг. Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого. УБ., 2016 он